

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/078/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Э.Энхбаатар Утас:51-261885 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn Аудитор: Ч.Мөнхбулган Утас: 51-261740 Цахим хаяг: munkhbulganch@audit.gov.mn Азуре хүлүг аудит ХХК-ийн захирал: Г.Мөнхбаяр Утас:70110090 Цахим хаяг: audit@azure.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Зохицуулах хороо, түүний үйл ажиллагаа	10
3.2 Зохицуулах хорооны гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	12
3.6 Худалдан авах ажиллагааны талаар	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА
Ж.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

2026.03.13 № 06/613
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2021 оны А/255 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 2.2 дахь хэсэгт Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын үзэл баримтлалыг тусгасан байна. Гэвч санхүү, нягтлан бодох бүртгэлийн программ хангамжид ажил гүйлгээг хөтлөхдөө Сангийн сайдын баталсан төсөвт байгууллагад мөрдөх дансны жишиг жагсаалтыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант хугацааны эцсээрх төлбөрт үйлчилгээний авлага 8,399.7 сая төгрөгийн үлдэгдлээс насжилт өндөртэй авлагад 3,561.7 сая төгрөгийн нөөц тооцож бүртгэсэн нь нийт авлагын 42.4 хувийг эзэлж байна.

Бусад асуудлын хэсэг

Төрийн аудитын байгууллага нь санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2025 онд 2,498.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, 2,785.7 сая төгрөгийн хөтөлбөр арга хэмжээ, 15,440.8 сая төгрөгийн урсгал зардал гаргахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 793.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын, 12,831.8 сая төгрөгийн урсгал зардал, 2,042.5 сая төгрөгийн хөтөлбөр арга хэмжээний зардал гаргажээ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамрахгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	32,728,934,614.97	39,626,328,947.87
1.1.2	Дансны авлага	2,942,058,403.79	4,838,039,342.04
1.1.4	Бусад авлага	211,616,181.63	1,083,572,503.31
1.1.6	Бараа материал	24,302,618.35	32,423,649.89
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	9,512,353.33	9,805,182.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	35,916,424,172.07	45,590,169,625.11
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	6,353,962,276.59	5,971,939,795.35
1.2.2	Биет бус хөрөнгө	3,625,653,588.28	3,231,519,177.48
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9,979,615,864.87	9,203,458,972.83
1.3	Нийт хөрөнгийн дүн	45,896,040,036.94	54,793,628,597.94
2	Өр төлбөр ба эздийн өмч		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.2	Ажиллагчидтай холбоотой өглөг	2,722,365.65	4,030,345.05
2.1.1.3	Бусад өглөг	56,661,249.62	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	348,037,408.40	161,274,813.70
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	407,421,023.67	165,305,158.75
2.2	Өр төлбөрийн нийт дүн	407,421,023.67	165,305,158.75
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	1,169,840,273.85	1,169,840,273.85
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,875,443,232.22	1,875,443,232.22
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,139,493,680.00	2,146,361,790.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	40,303,841,827.20	49,436,678,143.12
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг / алдагдал /	-	9,127,436,315.92
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг /алдагдал/	40,303,841,827.20	40,309,241,827.20
2.3.11	Эздийн өмчийн дүн	45,488,619,013.27	54,628,323,439.19
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	45,896,040,036.94	54,793,628,597.94

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	11,855,129,783.77	18,144,436,505.50
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг	11,855,129,783.77	18,144,436,505.50
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	3,740,663,003.02	5,277,681,882.69
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	978,202,321.63	441,683,133.31
9	Борлуулалт, маркетингийн зардал	4,676,966,069.19	4,727,451,425.30
10	Ерөнхий ба удирдлагын зардал	6,998,200,700.04	8,025,994,847.97
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	1,831,650,365.24	1,982,452,437.30
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(790,513.24)	(351,814.34)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(12,672,887.73)	(114,680.67)
17	Бусад ашиг (алдагдал) НА-ийн нөөц	(1,154,927,595.37)	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	1,898,786,977.61	9,127,436,315.92
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,898,786,977.61	9,127,436,315.92
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,898,786,977.61	9,127,436,315.92
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
25	Орлогын нийт дүн	1,898,786,977.61	9,127,436,315.92
26	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Дүн
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,169,840,273.85	1,875,443,232.22	2,139,493,680.00	38,405,054,849.59	43,589,832,035.66
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	1,169,840,273.85	1,875,443,232.22	2,139,493,680.00	38,405,054,849.59	43,589,832,035.66
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,898,786,977.61	1,898,786,977.61
2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,169,840,273.85	1,875,443,232.22	2,139,493,680.00	40,303,841,827.20	45,488,619,013.27
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	6,868,110.00	5,400,000.00	12,268,110.00
Залруулсан үлдэгдэл	1,169,840,273.85	1,875,443,232.22	2,146,361,790.00	40,309,241,827.20	45,500,887,123.27
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	9,127,436,315.92	9,127,436,315.92
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	1,169,840,273.85	1,875,443,232.22	2,146,361,790.00	49,436,678,143.12	54,628,323,439.19

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	13,602,360,345.30	20,523,108,064.34
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	9,365,422,107.05	16,225,260,367.55
	Бусад мөнгөн орлого	4,236,938,238.25	4,297,847,696.79
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	11,822,926,034.11	12,831,853,425.58
	Ажиллагчдад төлсөн	6,215,648,465.33	7,116,420,810.59
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	784,043,119.20	902,745,052.12
	Бараа материал худалдан авахад төлсөн	365,587,122.87	378,025,586.05
	Ашиглалтын зардалд төлсөн	110,293,419.44	127,126,042.53
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	110,926,752.63	122,032,566.44
	Бусад мөнгөн зарлага	4,236,427,154.64	4,185,503,367.85
1.4	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,779,434,311.19	7,691,254,638.76
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	256,159.86	1,139,328.46
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	256,159.86	1,139,328.46
	Хүлээн авсан хүүний орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	717,240,790.56	793,621,622.75
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	547,880,819.00	688,471,622.75
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	169,359,971.56	105,150,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(716,984,630.70)	(792,482,294.29)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Валютын ханшийн зерүү	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,025,460.34	1,378,011.57
	Валютын ханшийн зерүү	1,025,460.34	1,378,011.57
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,025,460.34)	(1,378,011.57)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,061,424,220.15	6,897,394,332.90
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	31,667,510,394.82	32,728,934,614.97
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	32,728,934,614.97	39,626,328,947.87

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/2025 гүйцэт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:			16,573,995.1	12,788,620.4	23,863,801.5	7,289,806.4	144.0	11,075,181.1	186.6
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	м.төг	11,855,129.8	11,312,495.9	18,144,436.5	6,289,306.7	153.1	6,831,940.6	160.4
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	м.төг	489,424.8	-	381,716.2	(107,708.6)	78.0	381,716.2	-
	Хүүгийн орлого	м.төг	3,740,663.0	1,400,124.5	5,277,681.9	1,537,018.9	141.1	3,877,557.3	376.9
	Бусад орлого	м.төг	488,777.5	76,000.0	59,966.9	(428,810.6)	12.3	(16,033.1)	78.9
2	Нийт орлого	м.төг	16,573,995.1	12,788,620.4	23,863,801.5	7,289,806.4	144.0	11,075,181.1	186.6
3	Нийт зардал	м.төг	13,506,817.1	15,440,789.8	14,735,898.7	1,229,081.6	109.1	(704,891.1)	95.4
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	13,121,550.1	14,672,707.6	14,056,691.1	935,140.9	107.1	(616,016.5)	95.8
4	Татварын өмнөх ашиг	м.төг	3,067,178.0	(2,652,169.3)	9,127,902.8	6,060,724.8	297.6	11,780,072.2	(344.2)
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	-	-	-	-	-	-	-
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	1,494,812.3	1,807,243.4	1,716,296.6	221,484.3	114.8	(90,946.8)	95.0
	а/ Орлогын татварт	м.төг	-	-	-	-	-	-	-
	б/ НӨТ	м.төг	-	-	-	-	-	-	-
	в/ НДШ	м.төг	792,304.6	1,015,097.6	924,929.8	132,625.2	116.7	(90,167.8)	91.1
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	666,781.1	746,364.8	746,364.8	79,583.7	111.9	-	100.0
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	19,239.9	22,562.0	19,239.9	-	100.0	(3,322.1)	85.3

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	1,086.6	2,500.0	3,682.5	2,595.9	338.9	1,182.5	147.3
	ж/ Бусад татварт /УТХ/	м.төг	15,400.0	20,719.0	22,079.6	6,679.6	143.4	1,360.6	106.6
7	Төрийн өмчийн НА өглөг	м.төг	-	-	-	-	-	-	-
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	121.0	142.0	124.0	3.0	102.5	(18.0)	87.3
9	Нийт цалингийн сан	м.төг	6,999,691.6	9,075,686.5	8,019,165.9	1,019,474.3	114.6	(1,056,520.7)	88.4
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	4,280.7	4,730.4	4,782.5	501.8	111.7	52.1	101.1
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.8	1.2	0.6	0.2	75.8	(0.6)	51.1
12	Хөрөнгө оруулалт	м.төг	1,086,871.3	2,498,235.5	793,621.6	(293,249.6)	73.0	(1,704,613.9)	31.8
13	Нийт авлага	м.төг	3,153,674.6	-	4,857,761.2	1,704,086.6	154.0	4,857,761.2	-
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-	-	-	-
14	Нийт өглөг	м.төг	407,421.0	-	165,305.2	(242,115.9)	40.6	165,305.2	-
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	407,421.0	-	165,305.2	(242,115.9)	40.6	165,305.2	-
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	-	-	-	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Зохицуулах хороо, түүний үйл ажиллагаа

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хуульд заасан зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт шийдвэр гаргах чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд Зөвшөөрлийн тухай, Харилцаа холбооны тухай, Шуудангийн тухай, Радио долгионы тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажилладаг бие даасан зохицуулах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг, Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Харилцаа холбооны зохицуулах хороо зорилгоо “Бид харилцаа холбооны чанартай, дэвшилтэт бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хэрэглэгчдийг хүртээмжтэй хангах, харилцан үр ашигтай хамтран ажиллах, ил тод, уян хатан зохицуулалтын тогтолцоог төгөлдөршүүлнэ” гэж тодорхойлсон байна.

Зохицуулах хороо нь Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10-т “Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлс болон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрөөс санхүүжнэ” гэж заасны дагуу үйл ажиллагааны орлогыг бүрдүүлж байна.

3.2 Зохицуулах хорооны гадаад, дотоод орчин

Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм нь Засгийн газрын 2002 оны 15 дугаар тогтоолоор анх батлагдсан бөгөөд 2016 оны 268 дугаар тогтоолоор шинэчилж, 2020 оны 65 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлтийг оруулсан байна.

Зохицуулах хороо үйл ажиллагаандаа Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, Шуудангийн тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгавар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай”;
- Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2025 оны А/168 тоот “Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам”.

Зохицуулах хорооны удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үнэллээ.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголтыг олж авснаа дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хорооны даргын 2021 оны А/255 тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн программ хангамжид ажил гүйлгээг хөтлөхдөө Сангийн сайдын баталсан төсвийн байгууллагын дагаж мөрдөх дансны жишиг жагсаалтыг ашигласан байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,897.6 сая төгрөгөөр буюу 19.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	32,728.9	39,626.3	6,897.4
Авлага	3,153.7	5,921.6	2,767.9
Бараа материал	24.3	32.4	8.1
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	9.5	9.8	0.3
Үндсэн хөрөнгө	9,979.6	9,203.5	(776.1)
Нийт хөрөнгө	45,896.0	54,793.6	8,897.6
Өр төлбөр	407.4	165.3	(242.1)
Эзэмшигчдийн өмч	45,488.6	54,628.3	9,139.7
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	45,896.0	54,793.6	8,897.6

Мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данснууд нөлөө бүхий өөрчлөлт орсон байна. Тухайлбал,

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 39,626.3 сая төгрөг болж, өмнөх оноос 6,897.4 сая төгрөгөөр өссөн нь арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдэл 1,275.8 сая төгрөг, хадгаламжийн дансны үлдэгдэл 38,350.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарснаас шалтгаалсан;
- Авлага дансны үлдэгдэл 5,921.6 сая төгрөг болж, өмнөх оноос 2,767.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд үйл ажиллагаатай холбоотой авлагын үлдэгдэл 1,895.0 сая төгрөгөөр өсөж, хуримтлуулж тооцсон хадгаламжийн хүүгийн 1,067.2 сая төгрөг авлага бүртгэсэн нь голлон нөлөөлсөн;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,203.5 сая төгрөг болж, өмнөх оноос 776.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 793.6 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, ТӨБЗГ-ын 2025 оны 254 дүгээр тогтоолын дагуу 379.0 сая төгрөгөөр хөрөнгийн үнийн шинэчлэн тогтоож, ашиглалтын хугацааг сунгасан, ТӨБЗГ-ын 2025 оны 65 дугаар тогтоолоор 67.3 сая төгрөгийн хөрөнгийг Үйлдвэрлэл, урлалын политехникийн коллежид балансаас баланст шилжүүлсэн, ТӨБЗГ-ийн 2025 оны 303, 444 дүгээр тогтоолуудаар 337.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж, тайлант хугацааны элэгдлийн зардалд 1,955.5 сая төгрөгийг бүртгэсэн зэрэг голлон нөлөөлсөн;
- Өр төлбөрийн дансны үлдэгдэл 165.3 сая төгрөг болж, өмнөх оноос 242.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд харилцагчид төлөх өрийг барагдуулж, ажилчидтай холбоотой 4.0 сая төгрөг, урьдчилж орсон орлого 161.3 сая төгрөгийн тооцоотой гарснаас тус тус шалтгаалсан;
- Эздийн өмч дансны үлдэгдэл 54,628.3 сая төгрөг болж, өмнөх оноос 9,139.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.16 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 268 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”-ийн 4.3.2-т “хорооны төсөв, ажлын төлөвлөгөөг батлах” гэж заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зардлын төлөвлөгөөг боловсруулж, хорооны хуралдаанаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны 251 дүгээр тогтоолоор 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зардлын төлөвлөгөө, 2026-2027 оны төсвийн төсөөллийг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 12,788.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 18,119.6 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2,498.2 сая төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 23,863.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 14,735.9 сая төгрөгийн зардал гарган, 9,127.9 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 23,863.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 7,289.8 сая төгрөг буюу 86.6 хувиар давж биелсэн нь үндсэн үйл ажиллагааны орлого 6,831.9 сая төгрөг, харилцах хадгаламжийн хүүгийн орлого 3,877.6 сая төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 14,735.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 704.9 сая төгрөг буюу 4.6 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь удирдлагын зардлын гүйцэтгэл 616.0 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 90.1 сая төгрөгөөр гүйцэтгэл дутуу гарсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 12 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 793.6 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

Биет бус хөрөнгө: Зохицуулах хорооны биет бус хөрөнгийн дансанд үйл ажиллагаатай холбоотой 2,468.8 сая төгрөгийн өртөгтэй 75 программ хангамжийг бүртгэлд тусгасан байна. Тайлант онд уг 6 программд нэмэлт хөгжүүлэхтэй холбоотой 105.1 сая төгрөгийн нэмэлт зардал гарсан байна. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Ординат ХХК-аас худалдан авсан “Unicus” санхүүгийн программыг ашиглаж байна.

Унаа хоол: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, 16.5.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8, 61 дүгээр зүйлийн 61.1.10 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дах заалт, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтын 8.4 дэх заалт, Хорооны даргын 2024 оны А/350 тоот тушаалаар 18.0 мянган төгрөгөөр хоол, унааны хөнгөлөлтийг тогтоосон байна. Тайлант хугацаанд хоол унааны хөнгөлөлтөд 596.6 сая төгрөг төсөвлөж, 425.1 сая төгрөгийг зарцуулж, 171.5 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Хурал, цуглаан, форум: Тайлант хугацаанд 4 удаагийн сургалт, 7 удаагийн хурал зөвлөгөөнийг 224.7 сая хийхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 10 сургалт, арга хэмжээг зохион байгуулж 204.9 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хэвлэл мэдээлэл: Зохицуулах хороо нь ажил гүйцэтгэх гэрээний дагуу хүүхдийн захидал бичгийн уралдаан нэвтрүүлэг, радио давтамж ашиглах зөвлөмжийн мэдээллийг түгээх зорилгоор Улаанбаатар телевиз ХХК-д 4.0 сая төгрөг, Жем сэтгүүлд 2.8 сая төгрөгийг төлж, нийт 6.8 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Аудитаар дээрх зардлуудтай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

3.6 Худалдан авах ажиллагааны талаар

Зохицуулах хороо нь тайлант онд нийт 4,368.7 сая төгрөгийн 75 төрлийн бараа, ажил үйлчилгээг хэрэгжүүлэхээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байна. Мөн ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс 101.0 сая төгрөгийн 2 худалдан авалт хийхээр төлөвлөсөн байна.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2,372.5 сая төгрөгийн 67 худалдан авалтыг хийж ажилласан байна. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл нь 55.4 хувьтай байгаа нь 1,629.1 сая төгрөгөөр суурин хяналтын станц 1 сэт шинээр худалдан авч суурилуулах нээлттэй сонгон шалгаруулалтын гэрээ байгуулаагүй, зарим худалдан авах ажиллагааг зохион байгуулах шаардлагагүй болсон зэргээс шалгаалсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн зохицуулах хороо, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагааг сайжруулах зардлын эдийн засгийн ангилал, үндсэн хөрөнгийн үнэ цэнийг шинэчлэн тогтоох, санхүүгийн тайланг хугацаанд ирүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Азуре Хүлүг Аудит” ХХК-ийн аудитын менежер Б.Өлзийхутаг, туслах аудитор Г.Нандин-Эрдэнэ, Г.Баасанбат нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер П.Болортуяа, гүйцэтгэх захирал Г.Мөнхбаяр нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Ч.Мөнхбулган, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг нар тус тус хэрэгжүүлсэн.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 1/377 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 13,506.8 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож 135.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага өдөр тутмын үйл ажиллагааг хуульд нийцүүлэн зохион байгуулж, зарим худалдан авалтыг зогсоох, хурал, сургалтыг онлайн зохион байгуулах, томилолт, зочин төлөөлөгч, автомашинтай холбоотой зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан. Зардлын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад бичиг хэргийн зардал 14.7 сая, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардал 37.7 сая, байр түрээсийн зардал 4.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 233.7 сая,

дотоод томилолтын зардал 24.2 сая төгрөгөөр буурч гарсан байна. Харин гэрэл, цахилгааны зардал 20.1 сая, тээвэр шатахууны зардал 1.9 сая төгрөг, аж ахуйн материалын зардал 9.6 сая төгрөгөөр өссөн нь үнийн өсөлттэй холбоотой байна.

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд горим сорил хэрэгжүүлэхэд байгууллагын хөрөнгөөр биеийн тамир, спортын уралдаад оролцох, зохион байгуулахад 9.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.8-д “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахад зардал гаргасан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 67.5 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 161 мэдээллийг хугацаанд байршуулж ажилласан байна.

Шилэн дансны цахим хуудаст байршуулбал зохих цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 51,727.8 сая төгрөгийн 551 ажил гүйлгээ, 286 бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээллийг хуульд заасан хугацаанд иж бүрэн байршуулсан байна.

4.4.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт

Илрүүлэлт: Цахим эрсдэлээс хүүхэд хамгаалах багц хичээлийн агуулга боловсруулах 57.8 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааг тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлагад нийцүүлж үнэлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "*Захиалагч санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг оролцогчоос шаардаж болно*", 16.5-д "*Оролцогч захиалагчийн тогтоосон санхүүгийн чадавхын шаардлагыг хангасан байна*", 26 дугаар зүйлийн 26.1-д "*Захиалагч оролцогчоос ирүүлсэн тендерийг шаардлагад нийцэх эсэхийг энэ зүйлд зааснаар хянан үзнэ*", 26.4.4-т "*тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага хангасан байх*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны оролцогчдоос ирүүлсэн материалыг үнэлэхдээ тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасны дагуу үнэлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, цалингийн зардлын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулж, завсрын аудитаар 9.8 сая төгрөгийн 3 алдаа, зөрчлийн талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, 9.7 сая төгрөгийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийг жилийн эцсийн санхүүгийн тайланд нэмж тусгав.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 152.9 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, өмнөх аудитын шийдвэрийн биелэлт хангалтгүй асуудалд 2 албан шаардлага, төсвийн төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслэж хийх талаар өгсөн 1 зөвлөмжийг нотлох баримтад үндэслэн хянаж үнэлэхэд бүрэн хэрэгжүүлсэн байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 2. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	152.9	2	152.9	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	3	152.9	3	152.9	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудад анхаарах шаардлагатай гэж шийдвэрлэлээ. Үүнд:

- Зохицуулах хорооны мөнгөн хөрөнгийн удирдах, арилжааны банканд байршуулахтай холбоотой шалгуур үзүүлэлт, болзошгүй эрсдэлийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, мөнгөн хөрөнгөнд тавих хяналт сайжруулах;
- Хорооны бүртгэлд тусгагдсан насжилт өндөртэй авлагыг цуглуулах талаар авлага барагдуулах комиссын ажлын тайлан, үр дүн.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 1,067.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав.

Залруулсан алдаа: НББОУС-8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа стандартын 41-д "...тайлант үед илрүүлсэн уг тайлант үеийн боломжит алдааг тухайн үеийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө засварладаг...", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-т "нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж тус тус заасны дагуу дараах залруулгуудыг хийсэн. Үүнд

- Тайлант хугацааны эцэст 1,067.1 сая төгрөгийн хүүгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй, санхүүгийн тайлагналын "Тасалбар болголт", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангаагүй алдааг залруулсан.

Аудитаар нийт 25.1 сая төгрөгийн зөрчил² илэрсэнд, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 25.1 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн 25.1 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 109.9 сая төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шалгагдагч этгээд нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад хуульд заасан цаглабарт хугацаанд хүргүүлээгүй, 10 хоног хоцроосон буюу 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлийн 9-т "Төрийн болон орон нутгийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийлгэнэ” гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжид заасан цаглабарт хугацаанд хүргүүлж хэвших;

2. Зардлын ангилалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж (210801) эдийн засгийн ангиллаас 25.1 сая төгрөгийн газрын төлбөр төлсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт “*Эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-д 210801 -Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж “*Гуравдагч этгээдийн багц үйлчилгээг худалдан авахад төлөх энэ бүлэг (2108)-т зааснаас бусад ажил, үйлчилгээний төлбөр хураамжууд энд хамаарна*” гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын ангиллаас эдийн засгийн ангилал зөрчиж худалдан авалт хийхгүй байх, зардлын эдийн засгийн ангиллыг Сангийн сайдын баталсан журамд заасныг дагуу бүртгэх.

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 18.5 сая төгрөгийн 19 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “*Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*” гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, өртгийг шинэчлэн тогтоож, эрх бүхий байгууллагын шийдвэрээр бүртгэлд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Тайлант хугацааны эцэст 1,067.2 сая төгрөгийн хүүгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.	1	1,067,156.6	1	1,067,156.6	-	-	1	1,067,156.6	-	-	-	-
	Дүн	1	1,067,156.6	1	1,067,156.6	-	-	1	1,067,156.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
1	Шалгагдагч этгээд нь 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр төрийн аудитын байгууллагад санхүүгийн тайлангаа хүргүүлсэн байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
2	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж (210801) эдийн засгийн ангиллаас 25.1 сая төгрөгийн газрын төлбөр төлсөн байна.	1	25,122.0	-	-	-	-	1	25,122.0	-	-	-	-
3	Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 18.5 сая төгрөгийн 19 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
	Дүн	3	25,122.0	-	-	-	-	3	25,122.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хууль						
Байгууллагын хөрөнгөөр биеийн тамир, спортын уралдаан оролцох зардлыг гаргасан байна.	1	9,710.0	1	9,710.0	-	-
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль						
Цахим эрсдэлээс хүүхэд хамгаалах багц хичээлийн агуулга боловсруулах зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааг тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлагад нийцүүлж үнэлээгүй байна.	1	57,800.0	1	57,800.0	-	-
Дүн	2	67,510.0	2	67,510.0	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 553/A0150079

Улаанбаатар хот

САГ-2026/78/КА-СТА-ТВА

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын хөрөнгөөр биеийн тамир, спортын уралдаан зохион байгуулж, оролцоход 9,710,000.00 (есөн сая долоон зуун арван мянган) төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахад зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга (Ж.Бат-Эрдэнэ), санхүү хэлтсийн дарга (Н.Халиунаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

Г.МӨНХБАЯР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 552/АД150079

Улаанбаатар хот

САГ - 2026/78/НА - СТА - ТӨА

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахим эрсдэлээс хүүхэд хамгаалах багц хичээлийн агуулга боловсруулах 57,800,000.00 (тавин долоон сая найман зуун мянган) төгрөгийн зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааны үнэлгээг хийхдээ тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасан багийн гишүүн нь татварын өргүй байх шаардлагыг харгалзаж үзээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Захиалагч санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг оролцогчоос шаардаж болно", 16.5-д "Оролцогч захиалагчийн тогтоосон санхүүгийн чадавхын шаардлагыг хангасан байна", 26 дугаар зүйлийн 26.1-д "Захиалагч оролцогчоос ирүүлсэн тендерийг шаардлагад нийцэх эсэхийг энэ зүйлд зааснаар хянан үзнэ", 26.4.4-т "тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага хангасан байх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

- Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасны дагуу үнэлдэггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга (Ж.Бат-Эрдэнэ), санхүү хэлтсийн дарга (Н.Халиунаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

Г.МӨНХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0313 SAG-1.Docx